



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2025/8/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорноговь аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Аудитын менежер: Утас: 70523020 Аудитор:	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn У.Оюунтүлхүүр Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Б.Ариунбаатар Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....	2
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....</b>	<b>4</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>12</b>

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 1. Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (976) 7052 2734  
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2025.02.24 № 1-6/20  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.ЧУЛУУНТУЯА ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус байгууллага нь байгууллагын удирдлагын шийдвэргүйгээр Өмч хамгаалах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн 6,593.3 мянган төгрөгийн аж ахуйн материал, 16,987.0 мянган төгрөгийн сэлбэр хэрэгслийг акталж, данснаас хассан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2-т 2."Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах үүрэгтэй", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 15 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.2.3-т "Хуулийн этгээдийн эд хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавьж, шалгалтыг дотоод хяналтын нэгжтэй хамтран зохион байгуулж, холбогдох санал дүгнэлтээ гүйцэтгэх, удирдлага, түүнчлэн эрх бүхий дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх эрхтэй" гэж заасантай нийцэхгүй байна.

010020029

### Асуудлыг онцолсон хэсэг

Шилэн дансны системд зарлагын 428.8 сая төгрөгийн 14 гүйлгээнээс 409.3 сая төгрөгийн 13 ажил гүйлгээг хугацаа хоцроосон, 19.5 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, хөрөнгө зарцуулах нийт 317.2 сая төгрөгийн 43 тушаал шийдвэрээс 202.3 сая төгрөгийн 31 тушаалыг хугацаа хоцроосон байна. Өмнөх онд зөвлөмж хүргүүлсэн ба тайлант онд тус зөрчил давтагдан гарсан тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

### Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант хугацаанд цэвэр бохир усны зардалд нийт 10,282,800 төгрөг зарцуулсан ба 6 дугаар сард 6,946,580 төгрөг, 12 дугаар сард 3,614,160 төгрөгийг зарцуулж, цэвэр бохир усны зардлыг хэтрүүлсэн, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг баримталж ажиллаагүй байна.

### Бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд бусад асуудлын хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>217,264,989.20</b>	<b>218,316,382.53</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	6,422,555.00	6,422,555.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	6,422,555.00	6,422,555.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	6,422,555.00	6,422,555.00
31211	Төрийн сангийн харилцах	6,422,555.00	6,422,555.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	29,798,703.07	27,763,367.32
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	136,579.75	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	29,662,123.32	27,763,367.32
3351	Байгууллагаас авах авлага	29,662,123.32	27,763,367.32
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	181,043,731.13	184,130,460.21
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	172,313,361.13	176,002,540.21
35410	Бичиг хэргийн материал	3,920,600.00	3,299,800.00
35420	Аж ахуйн материал	55,304,523.63	55,809,377.71
35430	Сэлбэг хэрэгсэл	29,283,350.00	19,086,150.00
35450	Барилгын засварын материал	1,500,000.00	1,500,000.00
35470	Бусад хангамжийн материал	82,304,887.50	96,307,212.50
35600	Мал амьтад	8,730,370.00	8,127,920.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,553,687,956.31</b>	<b>2,831,880,763.38</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,553,687,956.31	2,831,880,763.38
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,463,895,289.35	2,742,482,763.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,459,288,983.96	1,478,229,138.96
39202	Хуримтлагдсан элэгдэл	(69,567,271.92)	(115,803,821.34)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	483,537,850.00	458,637,850.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(131,706,583.21)	(154,985,484.97)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	70,561,518.80	92,741,366.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,488,018.52)	(43,050,073.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76,812,016.60	71,806,982.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,147,867.51)	(31,580,444.49)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,254,175,160.60	1,714,221,427.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	(624,570,499.45)	(727,734,177.29)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	89,792,666.96	89,398,000.00
39301	Програм хангамж	3,586,000.00	3,586,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,191,333.04)	(3,586,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	89,398,000.00	89,398,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,770,952,945.51</b>	<b>3,050,197,145.91</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>139,416.00</b>	<b>5,463,088.33</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	139,416.00	5,463,088.33
<b>413</b>	<b>Өглөг</b>	139,416.00	5,463,088.33
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	58,916.00	106,522.33
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	53,000.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	27,500.00	5,356,566.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	5,197,066.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	27,500.00	159,500.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,770,813,529.51</b>	<b>3,044,734,057.58</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,770,813,529.51	3,044,734,057.58
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,405,764,735.81	1,405,764,735.81
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,204,612,362.85	1,478,532,890.92
51210	Өмнөх үеийн үр дүн	1,204,612,362.85	1,204,612,362.85
51220	Тайлант үеийн үр дүн	-	273,920,528.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	160,436,430.85	160,436,430.85
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,770,952,945.51</b>	<b>3,050,197,145.91</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,358,671,322.23</b>	<b>1,946,114,960.84</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,117,645,346.00</b>	<b>545,177,552.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,561,500.00	3,276,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,561,500.00	3,276,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,561,500.00	3,276,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	1,060,462,846.00	500,866,082.00
120018	үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	54,621,000.00	41,035,470.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,241,025,976.23</b>	<b>1,400,937,408.84</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	513,313,853.51	427,554,457.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	125,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	322,412,184.00	353,973,007.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	65,901,669.51	73,581,450.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	727,712,122.72	973,382,951.84
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	727,712,122.72	973,382,951.84
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,186,533,458.77</b>	<b>1,661,134,358.71</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,186,533,458.77</b>	<b>1,661,134,358.71</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,170,818,458.77	1,650,634,358.71
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	399,854,548.85	681,450,223.75
210101	Үндсэн цалин	239,622,437.10	345,174,350.00
210102	Нэмэгдэл	104,367,908.00	268,633,073.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,289,999.75	42,800,600.00
210104	Урамшуулал	33,574,204.00	24,842,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	50,656,551.65	86,560,641.78
210201	Тэтгэврийн даатгал	35,342,913.34	60,696,673.28
210202	Тэтгэмжийн даатгал	3,828,404.63	5,891,880.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,062,724.04	5,006,547.50
210204	Ажилгүйдлийн даатгал	765,679.79	1,463,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,656,829.85	13,501,841.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	40,635,561.47	42,315,566.39
210301	Гэрэл, цахилгаан	7,741,225.47	6,464,861.39
210302	Түлш, халаалт	30,756,976.00	35,550,625.00
210303	Цэвэр, бохир ус	2,137,360.00	300,080.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	62,491,034.50	80,841,884.81
210401	Бичиг хэрэг	5,190,800.00	5,251,938.89
210402	Тээвэр, шатахуун	38,140,960.00	34,740,407.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,768,240.00	3,834,137.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,001,964.00	1,449,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	8,329,070.50	35,566,401.92
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	2,444,700.00	12,349,244.00
210502	Хоол, хүнс	2,444,700.00	12,349,244.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,181,500.00	21,161,058.33
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	53,608.33
210602	Тавилга	20,000.00	-
210604	Урсгал засвар	2,161,500.00	21,107,450.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,861,100.00	14,494,500.00
210702	Дотоод албан томилолт	5,861,100.00	14,494,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	34,361,845.00	43,338,654.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,081,800.00	42,067,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	622,600.00	700,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	212,494.00	285,314.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	162,712.00	88,000.00
210807	Газрын төлбөр	282,239.00	197,840.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	572,331,617.30	668,122,585.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	413,286,827.50	437,572,682.00

**Хөвсгөл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,675,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	157,369,789.80	230,549,903.65
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>15,715,000.00</b>	<b>10,500,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>15,715,000.00</b>	<b>10,500,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,715,000.00	10,500,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,172,137,863.46</b>	<b>284,980,602.13</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,567,749.82</b>	<b>11,060,074.06</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	397,749.82	1,356,924.06
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,650,000.00	7,920,700.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал	520,000.00	1,782,450.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(3,567,749.82)</b>	<b>(11,060,074.06)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,168,570,113.64</b>	<b>273,920,528.07</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,250,385,755.04</b>	<b>1,433,805,222.16</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,561,500.00</b>	<b>3,276,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,561,500.00</b>	<b>3,276,000.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	2,561,500.00	3,276,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,561,500.00	3,276,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,247,824,255.04</b>	<b>1,430,529,222.16</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>520,112,132.32</b>	<b>457,146,270.32</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	125,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	322,412,184.00	353,973,007.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	72,699,948.32	103,173,263.32
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>727,712,122.72</b>	<b>973,382,951.84</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	727,712,122.72	973,382,951.84
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,080,450,184.04</b>	<b>1,425,465,622.16</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,050,858,370.72</b>	<b>1,398,776,954.84</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,035,143,370.72</b>	<b>1,387,678,954.84</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>399,795,632.85</b>	<b>681,509,139.75</b>
210101	Үндсэн цалин	239,563,521.10	345,233,266.00
210102	Нэмэгдэл	104,367,908.00	268,633,073.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,289,999.75	42,800,600.00
210104	Урамшуулал	33,574,204.00	24,842,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>50,793,131.40</b>	<b>86,317,539.70</b>
210201	Тэтгэврийн даатгал	35,479,493.09	60,453,571.20
210202	Тэтгэмжийн даатгал	3,828,404.63	5,891,880.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,062,724.04	5,006,547.50
210204	Ажилгүйдлийн даатгал	765,679.79	1,463,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,656,829.85	13,501,841.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>35,200,994.47</b>	<b>42,315,566.39</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,933,225.47	6,464,861.39
210302	Түлш, халаалт	26,130,409.00	35,550,625.00
210303	Цэвэр, бохир ус	2,137,360.00	300,080.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>44,451,078.00</b>	<b>33,503,467.00</b>
210401	Бичиг хэрэг	5,110,100.00	3,720,300.00
210402	Тээвэр, шатахуун	35,827,238.00	24,150,530.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,368,240.00	3,834,137.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,085,500.00	1,798,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>32,769,260.00</b>	<b>29,529,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,979,960.00	-
210602	Тавилга	695,000.00	675,000.00
210604	Урсгал засвар	30,094,300.00	28,854,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,808,100.00</b>	<b>14,547,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,808,100.00	14,547,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>44,137,045.00</b>	<b>72,283,432.00</b>

**Хөвсгөл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,857,000.00	71,012,278.00
210803	Даатгалын үйлчилгээ	622,600.00	700,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	212,494.00	285,314.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	162,712.00	88,000.00
210807	Газрын төлбөр	282,239.00	197,840.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>422,188,129.00</b>	<b>427,673,110.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	420,513,129.00	427,673,110.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,675,000.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>45,306,813.32</b>	<b>37,786,667.32</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>15,715,000.00</b>	<b>11,098,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,715,000.00	11,098,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>29,591,813.32</b>	<b>26,688,667.32</b>
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	29,591,813.32	26,688,667.32
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>169,935,571.00</b>	<b>8,339,600.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>173,870,571.00</b>	<b>8,339,600.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>173,870,571.00</b>	<b>8,339,600.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>173,870,571.00</b>	<b>8,339,600.00</b>
222001	Тоног төхөөрөмж	14,820,000.00	8,339,600.00
223001	Бусад хөрөнгө	159,050,571.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(173,870,571.00)</b>	<b>(8,339,600.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(3,935,000.00)</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>6,422,555.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>6,422,555.00</b>	<b>6,422,555.00</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,405,764,735.81	160,436,430.85	36,332,049.21	1,602,533,215.87
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(289,800.00)	(289,800.00)
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,405,764,735.81</b>	<b>160,436,430.85</b>	<b>36,042,249.21</b>	<b>1,602,243,415.87</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	1,168,570,113.64	1,168,570,113.64
C08	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,405,764,735.81</b>	<b>160,436,430.85</b>	<b>1,204,612,362.85</b>	<b>2,770,813,529.51</b>
D01	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,405,764,735.81</b>	<b>160,436,430.85</b>	<b>1,204,612,362.85</b>	<b>2,770,813,529.51</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,405,764,735.81</b>	<b>160,436,430.85</b>	<b>1,204,612,362.85</b>	<b>2,770,813,529.51</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зерүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	273,920,528.07	273,920,528.07
D09	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,405,764,735.81</b>	<b>160,436,430.85</b>	<b>1,478,532,890.92</b>	<b>3,044,734,057.58</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,066,602,500.00	976,658,951.84	89,943,548.16	91.6
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,066,602,500.00	968,319,351.84	98,283,148.16	90.8
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,054,802,500.00	957,221,351.84	97,581,148.16	90.8
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	731,887,800.00	681,083,889.75	50,803,910.25	93.1
210101	Үндсэн цалин	337,142,000.00	345,233,266.00	(8,091,266.00)	102.4
210102	Нэмэгдэл	303,382,400.00	268,633,073.75	34,749,326.25	88.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,080,000.00	42,800,600.00	2,279,400.00	94.9
210104	Урамшуулал	46,283,400.00	24,416,950.00	21,866,450.00	52.8
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	94,331,500.00	86,317,539.70	8,013,960.30	91.5
210201	Тэтгэврийн даатгал	65,055,900.00	60,453,571.20	4,602,328.80	92.9
210202	Тэтгэмжийн даатгал	5,855,200.00	5,891,880.00	(36,680.00)	100.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,318,900.00	5,006,547.50	2,312,352.50	68.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,463,700.00	1,463,700.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	14,637,800.00	13,501,841.00	1,135,959.00	92.2
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	50,718,100.00	42,315,566.39	8,402,533.61	83.4
210301	Гэрэл, цахилгаан	8,451,000.00	6,464,861.39	1,986,138.61	76.5
210302	Түлш, халаалт	36,966,500.00	35,550,625.00	1,415,875.00	96.2
210303	Цэвэр, бохир ус	5,300,600.00	300,080.00	5,000,520.00	5.7
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	34,048,600.00	32,584,224.00	1,464,376.00	95.7
210401	Бичиг хэрэг	3,870,000.00	3,195,300.00	674,700.00	82.6
210402	Тээвэр, шатахуун	22,800,600.00	23,756,287.00	(955,687.00)	104.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,184,000.00	3,834,137.00	1,349,863.00	74.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	394,000.00	-	394,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	1,798,500.00	1,500.00	99.9
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	47,522,400.00	29,029,200.00	18,493,200.00	61.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,000,000.00	-	14,000,000.00	-
210602	Тавилга	5,000,000.00	675,000.00	4,325,000.00	13.5
210604	Урсгал засвар	28,522,400.00	28,354,200.00	168,200.00	99.4
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	12,447,800.00	8,607,500.00	3,840,300.00	69.1
210702	Дотоод албан томилолт	12,447,800.00	8,607,500.00	3,840,300.00	69.1
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	78,346,300.00	72,283,432.00	6,062,868.00	92.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	76,593,300.00	71,012,278.00	5,581,022.00	92.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	330,000.00	-	330,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	700,000.00	700,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	327,000.00	285,314.00	41,686.00	87.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	96,000.00	88,000.00	8,000.00	91.7
210807	Газрын төлбөр	300,000.00	197,840.00	102,160.00	65.9
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,500,000.00	5,000,000.00	500,000.00	90.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,500,000.00	5,000,000.00	500,000.00	90.9
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	11,800,000.00	11,098,000.00	702,000.00	94.1
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	11,800,000.00	11,098,000.00	702,000.00	94.1

Хөвсгөл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,800,000.00	11,098,000.00	702,000.00	94.1
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>8,339,600.00</b>	(8,339,600.00)	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	8,339,600.00	(8,339,600.00)	-
222001	Тоног төхөөрөмж	-	8,339,600.00	(8,339,600.00)	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,066,602,500.00	976,658,951.84	89,943,548.16	91.6
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,066,102,500.00	973,382,951.84	92,719,548.16	91.3
132001	Орон нутгийн төсвөөс	1,066,102,500.00	973,382,951.84	92,719,548.16	91.3
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	500,000.00	3,276,000.00	(2,776,000.00)	655.2
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	3,276,000.00	(2,776,000.00)	655.2
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>6,422,555.00</b>	(6,422,555.00)	-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>6,422,555.00</b>	(6,422,555.00)	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	төгрөгөөр	
		Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>430,457,603.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>430,457,603.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	430,457,603.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	425,250.00
210104	Урамшуулал	-	425,250.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	919,243.00
210401	Бичиг хэрэг	-	525,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	394,243.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	500,000.00
210604	Урсгал засвар	-	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	5,940,000.00
210702	Дотоод албан томилолт	-	5,940,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	422,673,110.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	422,673,110.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	457,146,270.32
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	457,146,270.32
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	353,973,007.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	103,173,263.32
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 49,547.2 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрснээс 15,161.0 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад бүрэн залруулж, залруулагдаагүй 5 зөрчилд 2 албан шаардлага, 3 зөвлөмж өгөв.

### 5.1. Залруулсан алдаа

1. Байгууллагын нийт ажилчдын цалин, нэмэгдлийг payroll цалингийн системийн цалин хөлсний нэмэгдэлтэй тулгахад нийгмийн даатгалын шимтгэлийн 106,522.33 төгрөгийн өглөгийг тайлагнаагүй, тайлант хугацааны эцэст Татвар болон Нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, цалинтай холбоотой өр авлагагүй тайлагнасан байна. Мөн цалингийн зардалд 99,000 төгрөгийн бараа материалыг хааж бүртгэснийг залруулав. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба

*төлбөрийн тооцоог хянаж, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэж заасныг зөрчсөн байна.

2. Түлш халаалтын зардлаас цэвэр бохир усны зардлыг зарцуулсан хэдий ч үр дүнгийн тайланд жинхэнэ зарлагаар тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “*үнэн зөв байх*”, 8 дугаар зүйлийн 8.4-т “*аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.
3. Тус байгууллага нь тайлант хугацаанд ОНХС-аас ажилчдын орон сууцны дулаан, цэвэр бохир усны шугамын ажилд 4.4 сая төгрөгийг зарцуулсан ба тус өглөгийг санхүүгийн тайланд тусгаж залруулсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж, ажил, гүйлгээг гарахаас нь хянан, баталгаажуулах*” гэж заасныг зөрчсөн байна.
4. Тус байгууллага нь малын нас дэвшилтийн орлогыг санхүүгийн үр дүнгийн тайланд нэмэгдүүлсэн дүнгээр бүртгэж тайлагнасныг залруулав. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “*үнэн зөв байх*” гэж заасантай нийцэхгүй байна.

## **5.2. Албан шаардлага**

1. Тайлант хугацааны эцэст байгууллагад өгөх 829.8 мянган төгрөгийн, хувь хүмүүст өгөх 159.5 мянган төгрөгийн өглөг, тээвэр шатахууны 1,074.7 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Мөн Нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлээгүйн улмаас 106.5 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*” гэж заасантай нийцэхгүй байна.

2. Шилэн дансны системд зарлагын 428.8 сая төгрөгийн 14 гүйлгээнээс 409.3 сая төгрөгийн 13 ажил гүйлгээг хугацаа хоцроосон, 19.5 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, хөрөнгө зарцуулах нийт 317.2 сая төгрөгийн 43 тушаал шийдвэрээс 202.3 сая төгрөгийн 31 тушаалыг хугацаа хоцроосон байна. Өмнөх онд зөвлөмж хүргүүлсэн ба тайлант онд зөрчил давтагдан гарсан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “*мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх*”, 4.1.3-т “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*”, 6 дугаар зүйлийн 6.4.5-т “*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ*”, 6.4.8-т “*бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ*”, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-т “*цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт*”, 8.4.8-т “*бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байнга ил тод, нээлттэй байлгана*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

## **5.3. Зөвлөмж**

### **1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**1.1. Илрүүлэлт:** Тус байгууллага нь тайлант хугацаанд цэвэр бохир усны зардалд нийт 10,282,800 төгрөг зарцуулсан ба 6 дугаар сард 6,946,580 төгрөг, 12 дугаар сард 3,614,160 төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, усны хэрэглээг хэмнэх” гэж заасантай нийцэхгүй байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:** Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, цэвэр бохир усны зардлыг хэмнэх;

## **2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

**2.1. Илрүүлэлт:** Тайлант хугацааны эцэст тээвэр шатахууны зардлыг хэтрүүлэн, үүссэн өглөгийг илүү дүнгээр шилжүүлж 1,074.7 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “*санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх*”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх зарчмыг хэрэгжүүлнэ*” гэж заасантай нийцэхгүй байна.

**2.2. Өгсөн зөвлөмж:** Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, цэвэр бохир усны зардлыг хэмнэх;

## **3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

**3.1. Илрүүлэлт:** Тус байгууллага нь байгууллагын удирдлагын шийдвэргүйгээр Өмч хамгаалах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн 6,593.3 мянган төгрөгийн аж ахуйн материал, 16,987.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, нийт акталж, данснаас хассан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2-т “*Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах үүрэгтэй*”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 15 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.2.3-т “*Хуулийн этгээдийн эд хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавьж, шалгалтыг дотоод хяналтын нэгжтэй хамтран зохион байгуулж, холбогдох санал дүгнэлтээ гүйцэтгэх, удирдлага, түүнчлэн эрх бүхий дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх эрхтэй*” гэж заасантай нийцэхгүй байна.

**3.2 Өгсөн зөвлөмж:** Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, байгууллагын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг өмч хамгаалах зөвлөл дүгнэлт гаргаж, удирдлагын шийдвэрээр устгах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүйг орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн ажил гүйлгээг үнэн зөв бүртгээгүйгээс өглөг бүртгэлд тусгаагүй алдаа	1	205.5	-	-	1	205.5	1	-		
Зардал хооронд гүйлгэн зарцуулахдаа жинхэнэ зарлагаар тайлагнаагүй алдаа	1	9,982.7			1	9,982.7	1	9,982.7		
Байгууллагаас зарцуулах санхүүжилтийг ОНХС-аас зарцуулсныг өглөгөөр бүртгээгүй	1	4,367.3	1	4,367.3			1	4,367.3		
Малын нас дэвшилтийг СҮДТ-нд нэмэгдүүлсэн дүнгээр бүртгэсэн алдаа	1	605.5			1	605.5	1	605.5		
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>15,161.0</b>	<b>1</b>	<b>4,367.3</b>	<b>3</b>	<b>10,703.7</b>	<b>4</b>	<b>15,161.0</b>		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	2,170.5			1	2,170.5		
Тээвэр шатахууны өглөгийг илүү дүнгээр шилжүүлж авлага үүсгэсэн	1	1,074.7					1	1,074.7
Байгууллагын удирдлагын шийдвэргүйгээр Өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн бараа материал акталсан	1	23,580.3					1	23,580.3
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>26,825.5</b>			<b>1</b>	<b>2,170.5</b>	<b>2</b>	<b>24,655.0</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Хуульд заасан мэдээллийг байршуулаагүй	1	-			1	-				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>			<b>1</b>	<b>-</b>				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй.	1	7,560.7						1	7,560.7	
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>7,560.7</b>						<b>1</b>	<b>7,560.7</b>	
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>7,560.7</b>			<b>1</b>	<b>-</b>		<b>1</b>	<b>7,560.7</b>	